



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/122

Булган сум

Шагналын зардал шийдвэрлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Тэргүүний ажилтны тэмдэг, үнэмлэх болон аймгийн Засаг даргын жуух, баярын бичгийн хэвлэмэл хуудас, хавтсыг хэвлүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 18,400,000 (арван найман сая дөрвөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6326010163

Аймгийн Засаг даргын 2026 оны
02 дугаар сарын 12-ны /ний өдрийн
А/122 дугаар захирамжийн хавсралт



**Аймгийн Засаг даргын шагналын
хэвлэлтийн зардал**

д/д	Шагналын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Жуух хавтас, дотор хэвлэл	400	15000	6,000,000
2	Баярын бичиг, дотор хэвлэл	300	12000	3,600,000
3	Аймгийн Тэргүүн хавтас, үнэмлэх	400	4500	1,800,000
4	Аймгийн Тэргүүний тэмдэг	400	17500	7,000,000
Дүн				18,400,000